

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/01/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Хөвсгөл аймаг

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 88090438 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас: 88688168 Цахим хаяг: Ichinkhorloog@audit.gov.mn

Төгс суурь стандарт Аудит ХХК-ийн

Ерөнхий захирал: Т.Батсайхан

Утас: 99010760 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Аудитын менежер: Г.Оюунгэрэл

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Ахлах аудитор: О.Хосбаяр

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа	16
4.2 Төлбөрийн акт	16
4.3 Албан шаардлага	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БШУЯам	Боловсрол шинжлэх ухааны яам
ДЗОУБ	Дэлхийн зөн олон улсын байгууллага
ГБХЗХГ	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ХАОНӨГ	Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/187
танай _____-ны № _____-Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН АЛАГ-ЭРДЭНЭ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Б.ПҮРЭВДОРЖ
ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	189,283,177.43	167,832,478.33
33	АВЛАГА	1,650,490.00	969,000.00
335	Бусад авлага	1,650,490.00	969,000.00
3351	Байгууллагаас авах авлага	1,650,490.00	969,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	187,632,687.43	166,863,478.33
351	Түүхий эд материал	3,330,980.00	5,195,459.40
35110	Тусгай зориулалттай материал	1,194,900.00	2,623,657.00
35130	Эм боох материал	2,136,080.00	2,571,802.40
35300	Бэлэн бүтээгдэхүүн	10,199,729.17	12,579,354.17
354	Хангамжийн материал	169,341,778.26	144,328,464.76
35410	Бичиг хэргийн материал	34,394,369.46	25,798,219.46
35420	Аж ахуйн материал	70,300,551.40	65,117,298.40
35440	Түлш, шатах тослох материал	47,943,640.00	24,880,000.00
35450	Барилгын засварын материал	7,926,430.00	12,054,800.00
35460	Хүнсний материал	3,594,742.90	9,981,102.40
35470	Бусад хангамжийн материал	5,182,044.50	6,497,044.50
35600	Мал амьтад	4,760,200.00	4,760,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	754,754,352.46	720,105,608.56
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	754,754,352.46	720,105,608.56
392	Биет хөрөнгө	687,470,352.46	652,821,608.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	711,493,680.00	711,493,680.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-171,819,450.18	-244,025,144.10
39203	Авто-тээврийн хэрэгсэл	26,000,000.00	26,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-17,333,333.28	-21,666,666.60
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	281,891,431.37	271,350,867.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	-213,554,473.47	-188,468,467.39
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	117,976,814.77	117,432,259.62
39208	Хуримтлагдсан элэгдэл	-70,664,637.52	-42,424,741.34
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,505,000.00	3,505,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,541,124.71	-2,891,624.67
39217	Ном	22,516,445.48	22,516,445.48
393	Биет бус хөрөнгө	67,284,000.00	67,284,000.00
39301	Програм хангамж	1,237,000.00	1,237,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,237,000.00	-1,237,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	67,284,000.00	67,284,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	944,037,529.89	887,938,086.89
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	63,052.71	30,242.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	63,052.71	30,242.00
413	Өглөг	63,052.71	30,242.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	62,388.71	30,242.00
4136	Бусад өглөг	664.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	664.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	943,974,477.18	887,907,844.89
51	Засгийн газрын хувь оролцоо	943,974,477.18	887,907,844.89
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	892,257,760.70	892,257,760.70
512	Хуримтлагдсан үр дүн	-326,710,936.10	-382,775,168.39
51210	Өмнөх үеийн үр дүн	-326,710,936.10	-326,708,536.10
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-56,066,632.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	378,427,652.58	378,425,252.58
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	944,037,529.89	887,938,086.89

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
		/төгрөгөөр/	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,060,502,802.49	1,095,380,174.92
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,019,502.49	44,902,459.10
120	Нийтлэг татварын бус орлого	25,019,502.49	44,902,459.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	25,019,502.49	44,902,459.10
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	340,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	24,679,502.49	44,902,459.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	51,921,600.00	67,896,715.82
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	983,561,700.00	982,581,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,494,400.00	6,071,915.82
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	6,071,915.82
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,494,400.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	50,427,200.00	61,824,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50,427,200.00	61,824,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,065,754,592.75	1,146,263,554.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,065,754,592.75	1,146,263,554.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,007,678,642.23	1,105,489,955.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	726,727,559.00	788,859,872.01
210101	Үндсэн цалин	726,727,559.00	759,266,298.23
210102	Нэмэгдэл	00.00	29,593,573.78
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,651,343.26	72,416,020.00
210201	Тэтгэврийн даатгал	64,207,737.26	70,001,499.90
210202	Тэтгэмжийн даатгал	7,317,591.00	620,160.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,854,073.00	489,408.35
210204	Ажилгүйдлийн даатгал	1,388,358.00	118,631.93
210205	Эрүүл мэндийн даатгал	13,883,584.00	1,186,319.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,392,995.39	69,437,354.82
210301	Гэрэл, цахилгаан	6,264,835.39	7,723,714.82
210302	Түлш, халаалт	5,051,360.00	61,713,640.00
210303	Цэвэр, бохир ус	76,800.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,197,020.39	8,087,450.00
210401	Бичиг хэрэг	202,500.00	60,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,293,420.39	6,469,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	387,000.00	399,500.00
210404	Ном, хэвлэл	220,000.00	182,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	453,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	641,100.00	976,050.00
2105	Нормативт зардал	36,966,284.56	36,187,200.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	928,630.00	3,547,961.60
210502	Хоол, хүнс	36,037,654.56	32,639,238.60

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,098,255.00	9,057,430.00
210604	Урсгал засвар	12,098,255.00	9,057,430.00
2107	Томилолт, зочны зардал	580,800.00	599,200.00
210702	Дотоод албан томилолт	580,800.00	599,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,358,900.00	2,565,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,858,900.00	1,965,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	116,705,484.63	118,279,928.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,078,400.00	12,198,350.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	102,627,084.63	106,081,578.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,075,950.52	40,773,599.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,963,068.60	17,944,120.90
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,322,568.60	17,944,120.90
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,640,500.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	44,396,817.31	21,617,967.28
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,396,817.31	21,617,967.28
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,716,064.61	1,211,511.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,716,064.61	1,211,511.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-5,251,790.26	-50,883,379.29
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	5,183,253.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	5,183,253.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-5,183,253.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-5,251,790.26	-56,066,632.29

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	892,257,760.70	-321,459,145.84	949,226,267.44
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	892,257,760.70	-321,459,145.84	949,226,267.44
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	-5,251,790.26	-5,251,790.26
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	892,257,760.70	-326,710,936.10	943,974,477.18
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	892,257,760.70	-326,710,936.10	943,974,477.18
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	2,400.00	2,400.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	892,257,760.70	-326,708,536.10	943,976,877.18
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	-2,400.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	-56,066,632.29	-56,066,632.29
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	892,257,760.70	-382,775,168.39	887,907,844.89

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
			/төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,035,483,300.00	1,050,477,715.82
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,035,483,300.00	1,050,477,715.82
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	983,561,700.00	982,581,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,494,400.00	6,071,915.82
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	6,071,915.82
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,494,400.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	50,427,200.00	61,824,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50,427,200.00	61,824,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,008,097,120.00	1,033,673,915.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,008,097,120.00	1,033,673,915.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	947,377,738.08	984,141,948.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	721,430,381.96	763,440,353.34
210101	Үндсэн цалин	630,739,755.36	503,497,291.23
210102	Нэмэгдэл	51,720,927.60	217,235,687.18
210104	Урамшуулал	38,969,699.00	42,707,374.93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,419,400.34	97,868,349.38
210201	Тэтгэврийн даатгал	68,333,500.34	68,388,767.49
210202	Тэтгэмжийн даатгал	7,271,400.00	7,392,135.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,817,200.00	5,910,428.37
210204	Ажилгүйдлийн даатгал	1,454,300.00	1,469,301.64
210205	Эрүүл мэндийн даатгал	14,543,000.00	14,707,716.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,341,635.39	46,373,714.82
210301	Гэрэл, цахилгаан	6,264,835.39	7,723,714.82
210302	Түлш, халаалт	38,000,000.00	38,650,000.00
210303	Цэвэр, бохир ус	76,800.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,568,020.39	10,914,700.00
210401	Бичиг хэрэг	637,100.00	399,500.00
210402	Тээвэр, шатахуун	4,499,920.39	7,438,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	387,000.00	399,500.00
210404	Ном, хэвлэл	295,000.00	332,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,826,500.00	279,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,922,500.00	2,065,200.00
2105	Нормативт зардал	46,856,900.00	33,249,324.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,108,700.00	2,333,194.00
210502	Хоол, хүнс	24,450,200.00	30,267,230.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	18,298,000.00	648,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,369,500.00	26,020,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,756,000.00
210602	Тавилга	00.00	9,000,000.00
210604	Урсгал засвар	3,369,500.00	15,264,800.00
2107	Томилолт, зочны зардал	580,800.00	599,200.00
210702	Дотоод албан томилолт	580,800.00	599,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,358,900.00	2,477,500.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,858,900.00	1,877,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,452,200.00	3,198,007.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,452,200.00	3,198,007.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,719,381.92	49,531,967.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,606,500.00	26,702,489.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,166,000.00	26,702,489.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,440,500.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	44,396,817.31	21,617,967.28
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,396,817.31	21,617,967.28
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,716,064.61	1,211,511.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,716,064.61	1,211,511.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	27,386,180.00	16,803,800.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	27,386,180.00	16,050,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,386,180.00	16,050,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	27,386,180.00	16,050,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	27,386,180.00	16,050,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-27,386,180.00	-16,050,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	753,800.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,017,171,000.0	1,020,910,521.7	-3,739,521.7	100.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,017,171,000.0	1,020,910,521.7	-3,739,521.7	100.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	989,647,000.0	994,208,032.7	-4,561,032.7	100.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	755,158,500.0	763,440,353.3	-8,281,853.3	101.1
210101	Үндсэн цалин	496,812,200.0	503,497,291.2	-6,685,091.2	101.3
210102	Нэмэгдэл	222,266,300.0	217,235,687.2	5,030,612.8	97.7
210104	Урамшуулал	36,080,000.0	42,707,374.9	-6,627,374.9	118.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,853,500.0	97,868,349.4	4,985,150.6	95.2
210201	Тэтгэврийн даатгал	72,378,400.0	68,388,767.5	3,989,632.5	94.5
210202	Тэтгэмжийн даатгал	7,618,800.0	7,392,135.5	226,664.5	97.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,095,100.0	5,910,428.4	184,671.6	97.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,523,700.0	1,469,301.6	54,398.4	96.4
210205	Эрүүл мэндийн даатгал	15,237,500.0	14,707,716.4	529,783.6	96.5

**Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Алаг-Эрдэнэ сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,520,000.0	46,170,000.0	-4,650,000.0	111.2
210301	Гэрэл, цахилгаан	7,520,000.0	7,520,000.0	00.0	100.0
210302	Түлш, халаалт	34,000,000.0	38,650,000.0	-4,650,000.0	113.7
2104	Хангамж, бараа материалын зардал	11,527,200.0	9,945,700.0	1,581,500.0	86.3
210401	Бичиг хэрэг	399,500.0	399,500.0	00.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	8,050,500.0	6,469,000.0	1,581,500.0	80.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	399,500.0	399,500.0	00.0	100.0
210404	Ном, хэвлэл	332,900.0	332,900.0	00.0	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	279,600.0	279,600.0	00.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,065,200.0	2,065,200.0	00.0	100.0
2105	Нормативт зардал	48,810,100.0	31,741,130.0	17,068,970.0	65.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	825,000.0	825,000.0	00.0	100.0
210502	Хоол, хүнс	46,670,400.0	30,267,230.0	16,403,170.0	64.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,314,700.0	648,900.0	665,800.0	49.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,050,000.0	40,314,800.0	15,264,800.0	160.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,050,000.0	16,050,000.0	00.0	100.0
210602	Тавилга	9,000,000.0	9,000,000.0	00.0	100.0
210604	Урсгал засвар	00.0	15,264,800.0	15,264,800.0	#DIV/0!
2107	Томилолт, зочны зардал	599,200.0	599,200.0	00.0	100.0
210702	Дотоод албан томилолт	599,200.0	599,200.0	00.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,465,500.0	1,465,500.0	00.0	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	865,500.0	865,500.0	00.0	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.0	600,000.0	00.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,663,000.0	2,663,000.0	00.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,663,000.0	2,663,000.0	00.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,524,000.0	26,702,489.0	821,511.0	97.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,524,000.0	26,702,489.0	821,511.0	97.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	27,524,000.0	26,702,489.0	821,511.0	97.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,024,391,000.0	997,292,918.1	27,098,081.9	97.4
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	982,371,000.0	938,184,182.7	44,186,817.3	95.5
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	982,371,000.0	938,184,182.7	44,186,817.3	95.5
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	42,020,000.0	59,108,735.4	17,088,735.4	140.7
132001	Орон нутгийн төсвөөс	42,020,000.0	59,108,735.4	17,088,735.4	140.7
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	69.00	69.00	00.0	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	42.00	42.00	00.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	26.00	26.00	00.0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,071,915.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,071,915.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,071,915.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	203,714.82

210301	Гэрэл, цахилгаан	203,714.82
2104	Хангамж, бараа материалын зардал	969,000.00
210402	Тээвэр, шатахуун	969,000.00
2105	Нормативт зардал	1,508,194.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,508,194.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,756,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,756,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,100,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	535,007.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	535,007.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,071,915.82
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,071,915.82
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,071,915.82
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагын авлагын данстай холбоотой, төсвийн төлөвлөл, зарцуулалттай холбоотой, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой өгсөн зөвлөмж, албан шаардлагыг тусгасан болно.

Аудитыг Төгс суурь стандарт аудит ХХК-ийн ахлах аудитор О.Хосбаяр, гүйцэтгэх захирал Т.Батсайхан, чанарын хяналтын менежер Г.Оюунгэрэл нар гүйцэтгэж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Ичинхорлоо, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ нар анхан шатанд чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хоёр дахь шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төгс суурьт стандарт аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 008 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Багшийн чиглүүлэг, эцэг эхийн

оролцоотойгоор сурагчдын хоцрогдлыг нөхөн бууруулж, бие даан сурах арга барилд дэмжлэг үзүүлэн хөгжүүлэх” гэж тодорхойлжээ.

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

1. Хосолсон сургалтын хэлбэрийг амжилттай хэрэгжүүлэх
2. Оношлох үнэлгээг хийж, гарааг тогтоож, суралцагчдын сурлагын амжилтыг ахиулах
3. Багш, сурагч, эцэг эх, ажилчид хоорондоо хамтран ажиллах сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх
4. “Алаг-Эрдэнэ хөтөч” дасгал ажлын дэвтрээр сурагчдыг өөрийн удирдлагатай суралцах арга барилд чиглүүлэх
5. Багш ажилчдын цахим орчинд ажиллах чадварыг сайжруулах
6. Багш нарын нэгдэл болон мэргэжлийн хэсгээрээ хамтран ажиллах нөхцөл боломжийг бий болгон дэмжих
7. Ахлах ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжааг эртнээс зөв олгох, чиглүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.7" хувьд өөрчлөлт орж "11.7" хувь, Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.5" хувьд өөрчлөлт орж "11.5" хувь болж өөрчлөгдсөн байна.
- Монгол улсын Засгийн газрын 2021 онд баталсан Үдийн хоолны норматив тогтоох тухай 237 дугаар тогтоолын 1-д “Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2021 оны 9-р сарын 1-ний өдрөөс 1500 төгрөг”-өөр тогтоосугай гэж заасныг хэрэгжүүлж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналтын комисс нь үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө гарган, улиралд нэг удаа хяналт хийж, тайланг захирлын зөвлөлд танилцуулж шийдвэрлүүлдэг ба төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналыг баримтжуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн 1.5 хувиар буюу 15.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 12.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 56.1 сая төгрөгөөр буюу 5.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн данс байна.

Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Хүснэгт 1.

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1.00	2.00	3=2-1
Дансны авлага	1.65	0.97	(0.68)
Бараа материал	187.63	166.86	(20.77)
Үндсэн хөрөнгө	754.75	720.11	(34.65)
Биет бус хөрөнгө	67.28	67.28	-
Нийт хөрөнгө	944.04	887.94	(56.10)
Дансны өглөг	0.06	0.03	(0.03)
Засгийн газрын оролцоо/Эздийн өмч	892.26	892.26	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	378.43	378.43	(0.00)
Хуримтлагдсан үр дүн	(326.71)	(382.78)	(56.06)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	944.04	887.94	(56.10)

Мөнгөн хөрөнгө данс нь оны эцэст үлдэгдэл байхгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 0.9 сая төгрөг болж 0.7 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд түлш халаалтын зардалд “Отгон ширэвгэр” ХХК-д 4.7 сая төгрөгийг давхардуулан шилжүүлж авлагаар тусгасан, шатахууны үнэ 0.9 сая төгрөгийг /100170115101 үндсэн данс/-аас НИК ХХК-д шилжүүлж нийт 4.9 сая төгрөгийг шилжүүлсэн байна. Сумын төрийн сан, уг ажил гүйлгээг бараа, ажил үйлчилгээ хүлээн авсан актыг шаардаагүй Засгийн газрын 2012 оны 205 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 4.1.-т “Төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцооны хүрээнд төсвийн байгууллага бүр бүртгэлийн данстай байна. Төрийн сан нь төсвийн байгууллагын батлагдсан төсвийн хуваарийн дагуу орлого, зарлагын гүйлгээ, төлбөр тооцоог ТСНД-аар хийж гүйцэтгэнэ.” заасан хяналтыг хангалтгүй хийж, гүйлгээ хийснээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 166.8 сая төгрөг болж 20.8 сая төгрөгөөр буурсан нь:

- Сумын ИТХ-ын 2021 оны 71 дугаар тогтоол, Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн захирлын А/54 тушаалаар 24.4 сая төгрөгийн бараа материалыг акталсан
- Сургуулийн хүүхдийн дотуур байр, сургуулийн хичээлийн байрны уурын зуухны халаалтын зардалд 68.2 сая төгрөгийг зарцуулж
- Сургуулийн багш, ажилчдын байрны урсгал засварт 6.0 сая төгрөг, гал тогооны засварт 3.0 сая төгрөгийг тус тус зарцуулсантай холбоотой байна.

Биет хөрөнгө дансны үлдэгдэл 67.3 сая төгрөг байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 27.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж,
- БШУЯ-аас эрх шилжин авсан 33.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж,
- Сумын ИТХ-ын 2021 оны 71 дугаар тогтоол, Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн захирлын А/55 тушаалаар 36.0 сая төгрөгийн хөрөнгийн хугацааг сунгаж өртгийг шинэчлэн орлого авсантай холбоотойгоор биет бус хөрөнгө өсөж,
- Сумын ИТХ-ын 2021 оны 71 дугаар тогтоол, Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн захирлын А/54 тушаалаар элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 53.6 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хассантай холбоотой байна.

Хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл 382.8 сая төгрөг болж 56.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 87.5 сая төгрөгөөр буюу 8.2 хувиар өссөн нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардал 36.8 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 58.0 сая төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн ИТХ-ын 2020 оны 11 дугаар тогтоолоор төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 920.5 сая төгрөгөөр батлуулж Аймгийн ИТХ-ын 2021 оны 14 дүгээр тогтоолоор 68.9 сая төгрөгийг нэмэлт тодотгол оруулсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 зориулалт арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,044.2 сая төгрөгийн төсөв батлагдсан. Үүнээс:

Улсын төсвөөс 982.4 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 61.8 сая төгрөгийг авч 22.2 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Батлагдсан төсвийг төсвийн саналтай харьцуулан хянахад үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдэл, бохир усны зардал, эд хогшил худалдан авах, хичээл үйлдвэрлэлийн зардал, урсгал засварын зардлуудыг тус тус бууруулж, тодотголоор үр дүнгийн урамшуулал, эд хогшил худалдан авах, хичээл үйлдвэрлэл, урсгал засварын зардлыг 68.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Алаг-Эрдэнэ сургууль нь дараах хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд:

Хөтөлбөр: 71802 Ерөнхий боловсрол

- Зориулалт арга хэмжээ: 81834 –Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө хөтөлбөр хэрэгжүүлэх
 81835 – Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах
 80109 – ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал
 81801 – Үдийн цай хөтөлбөр
 80802 - Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал
 80106 – Дотуур байр

Хөтөлбөр арга хэмжээний зардлыг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2

/сая.төгрөг/

Хөтөлбөр арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь

81834	Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө хөтөлбөр хэрэгжүүлэх	522.3	519.4	2.9	99.4
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	267.3	265.6	1.7	99.36
80109	ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	56.7	56.4	0.3	99.47
81801	Үдийн цай хөтөлбөр	27.5	26.7	0.8	97.09
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	0.21	0.0	0.21	0.0
80106	Дотуур байр	153.4	136.5	16.9	88.98

Нийт хөтөлбөрийн биелэлтийг 96.8 хувиар үнэлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийг хөтөлбөр тус бүрээр харуулав.

Хүснэгт 3

№	Орлого			Зарлага	Үлдэгдэл	Төвлөрүүлсэн
	Байгууллага	Зориулалт	Дүн			
1	“Чадварлаг багш чадварлаг сурагчид” төсөл	Ирээдүйгээ золиослохгүйгээр хамтдаа хөгжье	4.3	4.3	0.0	0.0
2	Боловсролын газар	Ариутгал, халдваргүйжүүлэл	0.3	0.3	0.0	0.0
4	Алаг-Эрдэнэ сум ЗД нөөц	Халдваргүйжүүлэлт	1.2	1.2	0.0	0.0
5	Хичээл хоцрогдол үнэлгээ	Хичээл үйлдвэрлэл	0.21	0.21		
ДҮН			6.1	6.1	0.0	0.0

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого төвлөрүүлээгүй ба орсон орлогыг зориулалтыг дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүссэн болон аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал гараагүй болно.

- Корона вирус-2019 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангасан.
- Улсын болон орон нутгийн онцгой комиссын шийдвэрээр хөл хорио тогтоосны улмаас сургалтын хэвийн үйл ажиллагаа хязгаарлагдаж байсан

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Хөвсгөл аймгийн Алаг Эрдэнэ ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн гол нөлөө бүхий асуудал болох Засгийн газраас баримталсан төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг хэрэгжүүлж 22.2 сая төгрөгийн хэмнэлт гарган төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд нийт 1,091.8 сая төгрөгийн 67 мэдээлэл оруулахаас 67.2 сая төгрөгийн 6 мэдээлэл хугацаа хоцроосон байна. Энэ нь Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 6.4.5, 6.4.8, 6.8.1 заалтын хүрээнд “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ”, “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”-н мэдээллүүдийг хугацаа хоцруулан мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Аудитаар Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж баталгаажуулав. Үүнд:

- Үдийн хоолны норматив тогтоох тухай Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 237 дугаар тогтоолоор ерөнхий боловсролын сургуулийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны нормативд зардлыг хэтрүүлээгүй нь уг тогтоолын холбогдох заалттай нийцсэн.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайланд авлагын данстай холбоотой, төсвийн төлөвлөлт, зарцуулалттай холбоотой, үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах талаар нийт 83.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, 2 зөвлөмж биелж, төсвийн төлөвлөлт, зарцуулалт, шилэн данстай холбоотой 2 зөвлөмж биелээгүй давтан гаргасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төрийн сангийн хяналтын талаар:

Сумын төрийн сан нь Засгийн газрын 2015 оны 24 дугаар тогтоолоор батлагдсан төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.8-д “Тухайн байгууллага журмын 7.5-д заасан төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг үндэслэх баримтын эх хувь, хяналтын хуудасны хамт ирүүлэх үүргийг хүлээнэ. Үндэслэх баримтад: Урсгал зардалтай холбоотой гүйлгээ хийх тохиолдолд төсвийн захирагчийн тушаал, төсвийн задаргааг баталсан

хавсралт, баталгаажуулсан цалингийн жагсаалт, товчоо, ажил, үйлчилгээ гүйцэтгэх, бүтээгдэхүүн худалдан авахтай холбоотой үнэлгээний хорооны шийдвэр, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, бараа, ажил, үйлчилгээ хүлээн авсан акт, нэхэмжлэх, бараа материалын орлого, зарлагын баримт, өр төлбөр байгааг нотолсон тооцоо нийлсэн акт, жижиг мөнгөн сангийн тайлан, банк дахь бэлэн мөнгөний дансны хуулга, хөрөнгийн зардалтай холбоотой гүйлгээ хийх тохиолдолд хөрөнгө оруулалтын санхүүжилт хийгдсэн дансны хуулга болон бусад бичиг баримт хамаарна. Үндэслэх баримтын мэдээллийн үнэн зөв байдлыг тухайн байгууллага хариуцна” заасны дагуу төсвийн зарцуулалт бүрийн үндэслэх баримтуудыг шалгах хянах үүрэгтэй.

Төсвийн зарлагын үндэслэх баримтыг хянаагүйгээс бараа ажил үйлчилгээг аваагүй байхад санхүүжилт бүрэн шилжсэн байгаа нь анхаарал татахуйц байгаа тул Аймгийн санхүү төрийн сангийн хэлтэст анхааруулах, гүйцэтгэлийн аудитаар үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 99.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 26.4 сая төгрөгийн алдааг залруулж, 72.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар санхүүгийн үр дүнгийн тайланг 26.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залрууллаа.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаардлага

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургууль нь өмнөх оны аудитын зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллаагүй, давтан зөрчил гаргасан тул дараах албан шаардлага хүргүүлж байна. Үүнд:

1. Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд нийт 1,091.8 сая төгрөгийн 67 мэдээлэл оруулахаас 67.2 сая төгрөгийн 6 мэдээлэл хугацаа хоцроосон байна. Энэ нь Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 6.4.5, 6.4.8, 6.8.1 заалттай нийцэхгүй байна.

Иймд гарсан зөрчлийг дахин давтахгүй байх, хэрэгжиж байгаа Шилэн дансны тухай хууль тогтоомжийг биелүүлж ажиллах албан шаардлага өгсөн.

2. Тайлант онд “Отгон ширэвгэр” ХХК-д 4.7 сая төгрөгийн түлш халаалтын зардлыг давхардуулан шилжүүлж авлагаар тусгасан, шатахууны үнэ 0.9 сая төгрөгийг НИК ХХК-д шилжүүлж нийт 5.6 сая төгрөгийг бүтээгдэхүүнийг нийлүүлээгүй байхад урьдчилан шилжүүлж зүй бус авлага үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дах “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, заалттай нийцэхгүй байна.

Иймд Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.8 дах хэсэгт “Зээлээр авсан бараа бүтээгдэхүүний төлбөрийг хүлээн авснаас хойш хуанлийн 30 хоногийн дотор бүрэн төлнө” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгсөн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Алаг-Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургууль	3	99.2	1	26.4	0	0	2	72.8	0	0